

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ 2 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2017.03.02

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газраас жил бүр газар тариалан, мал аж ахуйн салбарт гаргасан ажлын үр дүнг дүгнэн "УЛСЫН АВАРГА"-уудыг шалгаруулдаг уламжлалын дагуу эрхэлсэн салбартаа гаргасан ололт амжилтаа бэхжүүлж, үр өгөөжтэй ажиллаж байгаа аваргуудын шагналыг Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат гардуулан өгч, хүндэтгэл үзүүлсэн. Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаа, Засаг дарга Ш.Оргил болон аймаг, сумдын удирдлагуудын төлөөлөл байлцсан. Монгол Улсын Аварга малчнаар Мандал сумын Гүнбайн Ансай, Баянгол сумын Цэвээндоржийн Булган, Жавхлант сумын Түнтүүгийн Цэдэнсодном, Ерөө сумын Х.Балдандорж, Хушаат сумын Сайндайн Мөнхбат, "Монгол Улсын аварга тариаланч хамт олон"-оор Ерөө сумын "Их шинэстэй" ХХК, Цагааннуур сумын "Атартрейд" ХХК, "Сэлэнгэ тариа" ХХК, Хушаат сумын "Өгөөж Мандал Уул" ХХК, "Монгол Улсын аварга тариаланч"-аар Цагааннуур сумын "Сэлэнгэ тариа" ХХК-ий механикжуулагч М.Батсүх, Хушаат сумын "Элит үр" ХХК-ий механикжуулагч Т.Батбаатар нар шалгарлаа. Мөн аймгийн аваргуудыг тодруулан шагнал гардуулах ёслолын арга хэмжээг энэ сарын 23-ны өдөр аймгийн төвд зохион байгуулж, 2016 оны аймгийн "Аварга хамт олон"-оор Мандал сумын дуу бүжгийн "Мөнгөн хараа чуулга", "Төрийн захиргааны аварга ажилтан"-аар аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн З.Мандах, "Боловсролын салбарын аварга ажилтан"-аар Мандал сумын Улсын тэргүүний 5-р цэцэрлэгийн эрхлэгч Б.Бямбасайхан, "Эрүүл мэндийн салбарын аварга ажилтан"-аар Зүүнбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ц.Алтанцэцэг, "Соёл, урлагийн салбарын аварга ажилтан"-аар Ардын дуу бүжгийн "Сэлэнгийн долгио" чуулгын хөгжмийн багш Ж.Дашдаваа, "Биеийн тамир, спортын аварга ажилтан"-аар "Хараагийн хөх чоно" клубийн дасгалжуулагч Д.Алтантуяа, "Аялал жуулчлалын салбарынаварга ажилтан"-аар Сүхбаатар сумын "Эрчин" ХХК-ийн захирал Б.Дамдинпүрэв, "Санхүү, эдийн засгийн салбарын аварга ажилтан"-аар Аймгийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Г.Оюунцэцэг, "Худалдаа үйлчилгээний салбарын аварга ажилтан"-аар Зүүнбүрэн сумын "Цармын нуруу" хоршооны худалдагч Б.Отгончимэг, "Үйлдвэрлэлийн салбарынаварга ажилтан"-аар Сүхбаатар сумын "Мэргэн шувуут" ХХК захирал Д.Эрдэнэчимэг, "Зам тээврийн салбарын аварга ажилтан"-аар Сүхбаатар сумын "Тогоон чулуу" ХХК-ийн жолооч М.Ганболд, "Эрчим хүчний салбарын аварга ажилтан"-аар Сүхбаатар сумын "Сэлэнгэ энерго" ОНӨААТҮГ-ын зуухны машинч Д.Гинжбаатар, "Хууль хяналтын салбарын аварга ажилтан"-аар Алтанбулаг сумын ЗДТГ-ын архив, бичиг хэргийн эрхлэгч Ц.Энхтайван, "Тэргүүний сурагч"-аар Шаамар сумын Дулаанхаан тосгоны бүрэн дунд сургуулийн сурагч Б.Эрдэнэхөлөг нар тус тус шалгарсан.

Мөн аймгийн аврага малчинд нийт 14 сумын 28 малчны материал ирүүлснээс Орхонтуул сумын Б.Батбаатар, Орхон сумын Э.Баяраа, Жавхлант сумын П.Ганбат, Цагааннуур сумын Ц.Цэрэнчимэд, Мандал сумын Н.Лхагвагэрэл, А.Чүлтэмсүрэн, Ч.Ганбаяр, Түшиг сумын Б.Ишбаатар, Баруунбүрэн сумын Ж.Бүтэдмаа, Ерөө сумын С.Түмэн-Өлзий, Хушаат сумын Э.Гантөмөр, Баянгол сумын О.Нямжав, Зүүнбүрэн сумын Д.Чулуунбаатар нар "Аймгийн аварга малчин"-аар шалгарч, "Тэргүүний фермер"-ээр Хушаат сумын С.Сүхдаваа, Сант сумын Л.Бямбадорж малчид шалгарсан байна.

Аймгийн хэмжээний 85-аас дээш насны 420, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газарт ажиллаж байсан үе үеийн удирдлагууд, ажилтан албан хаагч 33, нийт 453 ахмадуудад аймгийн ИТХ-ын дарга болон Засаг дарга гарын бэлэг гардуулж, хүндэтгэл үзүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд, Улсын Онцгой комиссын дарга У.Хүрэлсүхээр ахлуулсан ажлын хэсэг Сэлэнгэ аймгийн өвөлжилт хүндэрсэн сумдад ажиллалаа. Ажлын хэсэг өвөлжилтийн нөхцөл байдалтай газар дээр нь

танилцах, онцгой комисст заавар зөвлөгөө өгөх, тулгамдсан зарим асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээ авч, Мандал, Баянгол, Сүхбаатар, Зүүнбүрэн, Цагааннуур сумдын өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж, Улсын нөөцөөс 320 тонн өвсийг үнэ төлбөргүй, 240 тонн тэжээлийг 50 хувиар хямдруулан олгоод байна. Мөн УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр тус аймагт ажиллаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, залуучуудыг дэмжих хөтөлбөр, сургалт сурталчилгаа, хөнгөлөлттэй зээл болон нийгмийн хамгааллын салбарын мэдээ мэдээлэл, цаашид баримтлах байр суурийн талаар сумын иргэд хөдөлмөрчид, төрийн албан хаагчдад мэдээлэл өглөө.

Монголын уламжлалт их баяр ХҮИ жарны “Алтан унжлагат” хэмээх гал улаагчин тахиа жилийн сар шинийн баярыг угтан “Цагаан сар-2017” үзэсгэлэн худалдааг аймгийн төв Сүхбаатар сумын “Сэлэнгэ олон улсын худалдааны төв”-д энэ сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулж, 16 сумын 95 аж ахуйн нэгж, иргэн 140 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнтэй оролцож, 15 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

“Иргэдээ сонсьё” телевизийн шууд нэвтрүүлгийн 2017 оны анхны дугаарыг зохион байгуулж, аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг оролцож иргэдээс гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн.

Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн ЭТИС хөтөлбөртэй хамтран “Орон нутгийн цогц хөгжил-Түншлэл” төслийн гишүүдэд сургалтын танхимыг бий болгон тохижуулан нээлтийг зохион байгуулж, аймгийн төрийн албан хаагчдад 4 сэдвээр сургалт зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд ХАСХОМ-ийг 2017 оны 02 сарын 15-ны өдөр цахимаар бүрэн авч бүртгэн бүрдүүлэлтийн программд шивж оруулсан. Нийт төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 240, улс төрийн 441, орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа 7 ТББ-ын удирдах албан тушаалтан хугацаандаа хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүллээ. Хугацаа хоцроосон буюу мэдүүлэг гаргахаас татгалзсан мэдүүлэгч байхгүй.

Онцгой байдлын талаар:

Монгол түмний үндэсний уламжлалт баяр билгийн тооллын сар шинийн баярын үеэр аж ахуйн нэгж байгууллага, иргэд, айл өрхүүд болзошгүй гал түймрийн аюулд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах, гол мөрний мөсөн дээгүүр зорчноос үүдэн гарах осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэл бүхий ухуулга сурталчилгаа, сэрэмжлүүлэг хүргэх, аж ахуйн нэгж байгууллагуудын галын аюулгүй байдалд үзлэг, шалгалт явуулж аюулгүй байдлыг хангуулах зорилго бүхий “Цагаан сар” нэгдсэн арга хэмжээг 2-р сарын 10-ны өдрөөс 2-р сарын 22-ны өдрийг хүртлэх хугацаанд аймгийн хэмжээнд зохион явууллаа. Арга хэмжээний хүрээнд хяналт шалгалтанд 112 аж ахуй нэгж байгууллага хамрагдсанаас гамшиг, осол, гал түймэр гарч болзошгүй 219 зөрчил дутагдал илрүүлснээс шалгалтын явцад 33 зөрчлийг арилгуулан бусад зөрчил дутагдлыг арилгуулахаар заавал биелүүлэх албан шаардлага 39, мэдэгдэл 69-г бичиж тухайн байгууллагын захирал, дарга нарт өгч биелэлтийг нь хангуулсан.

Болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, пийшин зуухны галлагаа, цахилгаан хэрэгсэл, хийн баллоны аюулгүй байдлыг хангах талаар 1536 айл өрхийн пийшин зуух, цахилгаан хэрэгсэл, хийн плитка, өвс хадлан тэжээл, өвөлжөө хашаа саравчийг үзэж шалган дээрх өрхийн 3084 иргэнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, аюулгүй байдлаа хангах тухай зөвлөмж өгч 2821 ширхэг сэрэмжлүүлгийн материалыг тарааж, Алтанбулаг, Баянгол, Сайхан, Мандал сумдын иргэд, сургууль, аж ахуйн нэгж байгууллагуудад болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх өдөрлөг, сургалтын арга хэмжээнд нийт 1757 иргэнийг хамруулан зохион байгуулсан.

Мэргэжлийн хяналтын ажил үйлчилгээний талаар:

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас тайлант сарыг “Урьдчилан сэргийлэх хяналтыг хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах сар” болгож 11 багц ажил төлөвлөн

хэрэгжүүлээ.Төлөвлөгөөний дагуу 2017 онд шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдахаар төлөвлөгдсөн иргэд, хуулийн этгээдийн төлөөлөлтэй ажил хэргийн уулзалт зохион байгуулж, байгаль орчин, геологи, уул уурхай, газрын харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүнсний чанар, аюулгүй байдал, эрүүл мэнд, мал эмнэлгийн хяналтын чиглэлээр салбарын сургалтуудыг хийж нийт 200 гаруй иргэд, хуулийн этгээдийн төлөөллийг хамруулсан. Мөн Монголын уламжлалт “Цагаан сар”-ын баярыг тохиолдуулан “Та сайхан шинэлээрэй” сэдэвт сарын аяныг зохион байгуулав. Сарын аяны хүрээнд аймгийн төв Сүхбаатар сумын “Гурван мэргэд” зах, “Сэлэнгэ” олон улсын худалдааны төв, Мандал сумын хүнсний захуудад “Хүнсний аюулгүй байдал, эрүүл хүнс” зурагт хуудсуудыг байршуулан, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын талаар 14 төрлийн 264 ш зөвлөмжүүдийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд тараан өгч сурталчиллаа.

МХЕГ-ын даргын баталсан удирдамжийг үндэслэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж 169 байгууллага, аж ахуйн нэгж, 85 иргэнийг хамруулсан. Мөн Сүхбаатар, Шаамар сумын 7 сургуулийн хоолны газар, дотуур байр, 6 цэцэрлэгийн хүүхдүүдийн хоол, хүнсний бүтээгдэхүүн, худалдаа үйлчилгээний газруудаас 74 дээж авч хоолны илчлэг, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч байгаа эсэхийг тодорхойлуулахаар лабораторийн шинжилгээнд хамруулахад 38 нь сөрөг, 11 нь эерэг үзүүлэлтэй гарсан. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад 142 зөрчлийг илрүүлж тэдгээрийг арилгуулахаар 84 заалт бүхий 14 албан шаардлагыг өгч биелэлтийг хангуулан, хууль тогтоомж зөрчсөн 3 иргэнд 720,0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар болон болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг хамтран Сүхбаатар сумын 8 томоохон дэлгүүр, 5 хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд савласан бүтээгдэхүүний тоо хэмжээнд болон бараан дээрх үнэ кассын машины үнэтэй тохирч байгаа эсэхэд шалгалт хийлээ. Уг арга хэмжээний хүрээнд олон улсын худалдааны төвд зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд ашиглагдаж байгаа жингүүд, мөн 100 г-аас 10 килограммаар савласан гурил, будаа, элсэн сахар, гоймон, пүнтүүз, чихэр, бялуу, талх, нарийн боов зэрэг 8 нэрийн 220 гаруй савласан бүтээгдэхүүнийг хамруулж, хяналт шалгалтыг хийн, илэрсэн зөрчлийг арилгах талаар үүрэг даалгавар, заавар зөвлөмжийг холбогдох байгууллагуудад өгч, ажиллалаа. Мөн “Хүүхэд харах үйлчилгээнд тавих шаардлага MNS 6540:2015” стандартаар хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдэд сургалт зохион байгуулж, сургалтанд 9 сумын 12 үйлчилгээний төвийн 13 хүүхэд харагч нар хамрагдлаа.

Үндэсний тохирлын тэмдэг хэрэглэх гэрээний хугацаа дууссан Шаамар сумын "Аргангат" нөхөрлөлийн "Шижир" зөгийн бал, Сүхбаатар сумын "Үжээд" ХХК-ийн "Сэлэнгэ шимт" цай, "Сэлэнгэ" талхан цехийн "Сэлэнгэ том талх" зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд баталгаажуулалтын ажил, Алтанбулаг, Мандал, Ерөө, Сүхбаатар, Сайхан, Баруунбүрэн сумын 9 аж ахуйн нэгж, иргэний 7 хүнсний дэлгүүр, 2 хоолны газарт холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийн тохирлын гэрчилгээ олгож, Мандал, Сүхбаатар, Шаамар, Цагааннуур, Орхонтуул сумдын 8 аж ахуйн нэгжийн 20 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж, Шаамар сумын иргэн Атархүүгийн “Байгалийн амт” нэрийн зөгийн балны хаяг шошгыг холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлүүлж, сорилт шинжилгээнд хамруулан аймгийн ХАҮТ-аас зураасан код авахад нь мэргэжил арга зүйн заавар өгсөн. Аймгийн төвд баригдах 50 МВт-ын дулааны цахилгаан станц төслийн ажлын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад шаардагдах анхдагч мэдээллээр ханган, 10 нэрийн 10 стандартын үйлчилгээ үзүүлсэн.

Мөн Шаамар сумын “Аргангат” нөхөрлөлийн “Шижир” нэрийн зөгийн цэвэр бал, Сүхбаатар сумын “Үжээд” ХХК-ийн “Сэлэнгэ” нэрийн цай, Сэлэнгэ талхан цехийн “Сэлэнгэ” нэрийн том талханд СХЗГ-аас МУ-ын Үндэсний тохирлын тэмдэг олгох шийдвэр 2017 оны 02 сарын 23-нд Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газрын ББЗ-ийн хурлаас гарсантай холбогдуулан дээрх аж ахуйн нэгжүүдтэй хамтран

бүтээгдэхүүнийг сорилт шинжилгээнд хамруулж, заавар зөвлөмжийг өгч төрийн байгууллага, иргэн аж ахуйн нэгжийн хоорондын холбоог хангаж ажиллалаа. Энэхүү Үндэсний тохирлын тэмдэг нь манай аймгийн хувьд брэнд бүтээгдэхүүн төдийгүй хэрэглэж буй анхдагч түүхий эд, сав баглаа боодлоос эхлэн хэрэглэгчийн гарт очих эцсийн бүтээгдэхүүн хүртэл ямар нэгэн хүнсний нэмэлтгүй чанартай бүтээгдэхүүн гэсэн илэрхийлэл юм.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Сангийн яамнаас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн тайланг 17 сум, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаас авч нэгтгэх, хүлээн авах ажил хийгдэж байна.

2016 оны аж ахуйн нэгж, байгууллагын жилийн эцсийн тайлан хүлээн авч дууссан ба аймгийн хэмжээнд нийт 1843 аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлан тушаахаас 1662 аж ахуйн нэгж, байгууллага тайлангаа ирүүлсэн бөгөөд ирц 90.2%-тай нэгтгэгдлээ. Шинээр 76 аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлж, 4 аж ахуйн нэгж, байгууллага шилжилт хөдөлгөөн хийлгэж, 7 аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан байна.

Тайлант сард аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 1'046 баримтаар 7'504'143'486 төгрөгийн гүйлгээ хийж, орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүжилтийг олгож, Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн мөнгийг иргэдэд олгох үйлчилгээг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Төрийн банк болон Капитал банкууд харилцан гэрээ байгуулж ажиллалаа.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2017 оны 1-р сарын танилцуулгыг боловсруулан гаргаж, аймгийн удирдлагуудад, 17 сум, 24 хэлтэс агентлагуудад хүргүүлж, танилцуулгыг www.selenge.nso.mn хуудсаар цахим хэлбэрээр мэдээлсэн.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	1,131,084.5	1,302,257.6	115.1
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	791,365.3	945,867.3	119.5
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	5,925,262.7	4,065,961.9	68.6
	Үүнээс: ТЗШ байгууллагын зарлага	3,949,351.5	2,716,629.2	68.8
	- Аймгийн төсвийн зарлагын дүн	1,055,779.3	853,631.9	80.9
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	25,150.3	25,150.3	100.0
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт			#DIV/0!
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт			#DIV/0!
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	94,375.8	94,375.8	100.0
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	450,000.0	450,000.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	3,944,168.9	3,944,168.9	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	1,929,093.2	1,929,093.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	1,046,429.6	1,046,429.6	100.0
	- Соёлын байгууллага	288,573.2	288,573.2	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	111,624.1	111,624.1	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	522,059.2	522,059.2	100.0
	- ГХБХБГазар	18,868.0	18,868.0	100.0

	- ГБХЗХГазар	27,521.6	27,521.6	100.0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	3,944,168.9	3,940,785.2	99.9
	- Ерөнхий боловсролын сургууль	1,929,093.2	1,929,093.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	1,046,429.6	1,046,429.6	100.0
	- Соёлын байгууллага	288,573.2	288,573.2	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	111,624.1	108,240.4	97.0
	- Эрүүл мэндийн байгууллага	522,059.2	522,059.2	100.0
	- ГХБХБГазар	18,868.0	18,868.0	100.0
	- ГБХЗХГазар	27,521.6	27,521.6	100.0
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	283,817.3	283,817.3	100.0
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	69,225.5	69,225.5	100.0
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	51,190.1	64,728.5	126.4
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	30,000.0	43,538.4	145.1
11	Тусгай сангуудын зарлага			#DIV/0!

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2016 XII - сар	2017 I- сар	<u>2016-XII</u> <u>2016-XI</u> /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа			
	Гурил /савласан, кг/	1200	1200	
	Талх /орон нутгийн, ш/	1100	1100	
	Нарийн боов /кг/	1900	2000	+100
	Будаа /кг/	2400	2400	
	Элсэн чихэр /кг/	2300	2200	-100
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	4500	5000	+500
	Үхрийн мах /кг/	5500	6500	+1000
	Адууны мах /кг/	4500	5500	+1000
	Ямааны мах /кг/	3000	4000	+1000
	Дотор мах, цувдай /цусгүй/	3000	3000	
	Хиам /чанасан, кг/	9800	10000	+200
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1400	1500	+100
	Сүү / савласан, л/	2500	2500	
	Тараг /задгай, л/	1500	1800	+300
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	11000	12000	+1000
	Айраг /л/	3500	3500	
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	
	Өндөг /ш/	300	320	+20
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	3400	3400	
	Өөхөн тос /кг/	1500	1800	+300
	Шар тос /кг/	10000	10000	
	Масло /задгай, кг/	5000	5000	
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	800	800	

	Лууван /кг/	600	600	
	Манжин /кг/	800	1000	+200
	Байцаа /кг/	1000	1500	+500
	Сонгино /кг/	1500	2000	+500
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3200	3200	
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2000	2500	+500
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1450	1450	
	Бензин А - 92	1530	1630	+100
	Дизелийн түлш	1640	1690	

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.Хууль эрх зүй, цагдаа, улсын бүртгэлийн талаар:

Аймгийн хэмжээнд 2017 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 78 холбогдогчтой, 175.9 сая төгрөгийн хохиролтой, 80 гэмт хэрэг бүртгэгдэж, 10 хэргээр буюу 14.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн гаралт Ерөө сум, Бугант тосгонд 50-66,7 хувиар, Сүхбаатар сумын 1, 3, 6-р баг, Алтанбулаг, Шаамар, Хүдэр, Цагааннуур, Баянгол, Орхон, Орхонтуул сумдад 1-5 дахин өсч, Сүхбаатар сум болон 4, 5 дугаар баг, Түшиг, Сайхан, Сант 33.3-66.7 сумдад хувиар, Сүхбаатар сумын 2, 8 дугаар баг, Жавхлант, Зүүнбүрэн, Хушаат сумдад 1-4 дахин хувиар тус тус буурч, Сүхбаатар сумын 7 дугаар баг, Дулаанхаан томгон, Мандал сумдад өмнөх оны мөн үетэй адил түвшинд, Баруунбүрэн суманд гэмт хэрэг бүртгэгдээгүй байна гэсэн тоон үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээнд 2017 оны 2 дугаар сард 164 төрөлт, 46 гэрлэлт, 40 нас баралт, 723 иргэнд цахим үнэмлэх, 58 үндэсний энгийн гадаад паспорт, ОХУ-ын хавсралт 4701 ширхэг олголтыг хийж, аймаг, хотруу шилжин явсан 321, шилжин ирсэн 223, сум дүүрэгт шилжин ирсэн 89, сум дүүрэгт шилжин явсан 85, баг хооронд шилжин ирсэн 217, баг хооронд шилжин явсан 208 шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлд 641 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 936 бүртгэл бүртгэгдэж, улсын тэмдэгтийн хураамж 296983, үйлчилгээний хураамж 16003591 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татвар 12933200 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.

2. Архивын талаар

Эрүүл мэндийн газартай хамтран сумдын Эрүүл мэндийн төвийн архив, бичиг хэрэг, дүн бүртгэл хариуцсан ажилтнуудад бүсчилсэн хэлбэрээр 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 30 хүн хамруулан “Баримт бичгийн стандарт”, “Хадгаламжийн нэгж бүрдүүлэх, хадгаламжийн нэгжид тавих шаардлага” зэрэг сэдвээр хичээл зааж, хууль сахиулах байгууллагуудын архив бичиг хэрэг, дотоод ажил хариуцсан ажилтнуудын уулзалт арга хэмжээг зохион байгуулж “Архив албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандарт” сэдвээр сургалт явуулсан.

Баримт бичгийн иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг аймгийн Хүнсний үйлдвэр болон Шим ХК-ийн 1960-1999 оны 112 хадгаламжийн нэгжид хийж, шинэчилсэн дансны бүртгэлийг боловсруулан аймгийн БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон ба дээрх хөмрөгийн 1960-1999 оны нийт 36 хадгаламжийн нэгжид бүрэн хэлбэрээр эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Сүхбаатар суманд шинээр баригдсан 300 хүний суудалтай усан бассейны барилгын ажил, Хүдэр сумын Төмрийн хүдэрийн нойтон баяжуулах үйлдвэрийн барилга зэрэг 2011-2016 оны нийт 18 хадгаламжийн нэгжээр нөхөн бүрдүүлэлтийн ажлыг хийж бүртгэлд хамруулсан байна.

Ард иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу цахим хэлбэрээр архивын хуулбар 80, мастер хувиар 26, цаасан суурьтай баримтнаас 21 лавлагаа гарган нийт архивын лавлагаа 127, цалингийн тодорхойлолт 17 гаргаж үйлчилсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

Боловсрол, соёл, урлагийн газрын даргаар ахлуулсан баг Орхон бүсийн сургууль, цэцэрлэг, соёлын төвийн үйлчилгээний чанар, хүртээмж, сэтгэл ханамжийн 133 цагийн хичээл, үйл ажиллагааг ажиглаж, 222 багш, соёл урлагийн 6 байгууллагын 75 ажилтан, албан хаагчдад зөвлөн туслаж, санал хүсэлтийг сонсож ажиллалаа.

Шаамар суманд 100 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай “Баясгалант ирээдүй” 2-р цэцэрлэг ашиглалтанд орж, сумын 60 гаруй хүүхэд хамрагдаж, 21 хүнийг ажлын байртай болголоо.

Орос хэлний Улсын олимпиадын 2-ын давааг Сүхбаатар сумын Улсын тэргүүний 2-р сургууль дээр зохион байгуулж 33 сургуулийн 28 багш, 76 сурагч оролцсноос Сайхан сумын ЕБС-ийн багш Э.Оюун-Эрдэнэ шалгаран Улсын олимпиадад аймгийг төлөөлөн амжилттай оролцож, 3-р байр эзлэн хүрэл медаль хүртлээ.

Өсвөрийн 100 буудалт даамын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, аймгийн Засаг даргын нэрэмжит насанд хүрэгчдийн сагсан бөмбөгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Монгол Улсын спортын мастер Ч.Үнэнмөнхийн нэрэмжит өсвөр үеийнхний чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Волейболын идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тус тус зохион байгуулж 1000 гаруй тамирчдыг хамрууллаа.

Аймгийн Засаг даргын нэрэмжит “Цас мөс”-ний өдөрлөгт 28 байгууллагын 880 гаруй хөдөлмөрчид амралтын өдрөөр эрүүл агаарт спортын 4 төрөлд өрсөлдөж, “Шилдэг Отог”-оор Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, “Спортлог номинаци”-д Гаалийн газар, “Идэвхитэй хамт олон”-оор Авто тээврийн үндэсний төвийн Сэлэнгэ салбар тус тус шалгарлаа.

Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдсан Алтан унжлагат хэмээх Гал тахиа жилийн сар шинийн баярт зориулсан барилдаанд Улсын цолтой 7, аймгийн цолтой 37 нийт 64 бөх барилдсанаас Монгол Улсын харцага Б.Одгэрэл түрүүлж, аймгийн хурц арслан Б.Эрдэнэхүү үзүүрлэж Монгол Улсын начин Ч.Баянмөнх, аймгийн заан Б.Оргилбаатар нар шөвгөрсөн бөгөөд барилдааны үеэр аймгийн ахмад бөхчүүд, харваачдад хүндэтгэл үзүүллээ.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2017 оны 01-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 856 байсан бол 60 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 17 ажлын байранд 15 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 67 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 834 болсон.

Тайлант сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 2314 иргэнд 624,899,600 төгрөг, жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2111 эхэд 145,369,300 төгрөг, ахмад настны тусламж, хөнгөлөлт 5737 иргэнд 342,585,000 төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1160 иргэнд 148,027,800 төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж 683 иргэнд 55,647,400 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 115 иргэнд 22,708,500 төгрөг, алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 54 иргэнд 14,886,700 төгрөг, эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 6683 иргэнд 909,840,000 төгрөг, нийт нийгмийн халамжийн сангаас 18857 иргэнд 2,263,964,300 төгрөгийг олгосон байна.

3.Эрүүл мэндийн талаар

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогын хүрээнд сум орон нутгийг их эмчээр хангах зорилгоор Баруунбүрэн, Жавхлант, Хүдэр сумдын эрүүл мэндийн төвийг их эмчээр хангаж, аймгийн Нэгдсэн эмнэлэгт гарсан хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн эмнэл зүй, эмгэг судлалын хурлыг зохион байгуулж, холбогдох эмч, мэргэжилтнүүдийг байлцуулан гарсан алдаа дутагдал, зөвлөмж хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Улирлын томуугийн эсрэг вакцинаар эмч, эмнэлгийн ажилчид, Онцгой байдлын газар, Хилийн цэргийн 1468 ажиллагсдыг дархлаажуулж, “Өсвөр үе, залуучуудад

бэлгийн боловсрол олгох, залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэнд"-ийн асуудлаар сургалт, хэлэлцүүлэгийг" Сүхбаатар, Шаамар, Алтанбулаг суманд зохион байгуулж эрүүл мэндийн салбарын 100 эмч, мэргэжилтнийг хамруулан, "Хүүхдэд үзүүлэх анхан шатны тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулъя" сэдэвт ЕБС, цэцэрлэгийн эмч нарыг чадавхижуулах онол-дадлагын сургалтыг 51 хүнийг хамруулан, "Өсвөр үеийн эрүүл мэнд" сэдэвт сургалтыг 140 гаруй эцэг эхчүүдэд, 35 багш, ажилчдад "Цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээлийн онцлог" сэдэвт сургалтыг, "Томуу, томуу төст өвчин" сэдэвт сургалтыг хил хамгаалах 0243-р ангийн 53 бие бүрэлдэхүүнд тус тус зохион байгууллаа.

Алтанбулаг, Жавхлант, Шаамар, Хүдэр сум, Дулаанхаан тосгонд ЭХО оношилгоо, хүүхэд, эмэгтэйчүүд, зүрх судас, мэдрэл, сэтгэцийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг явуулж, нийт давхардсан тоогоор 1639 хүнийг хамруулж, сэтгэцийн эмчийн үзлэгээр шинээр 28, хуучин 9 хүнд IQ-ийн түвшин тогтоолоо.

Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах, боловсролын байгууллагад ажиллаж байгаа эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор онол, дадлага хослуулан аймгийн сургууль, цэцэрлэгийн эмч нарыг чадавхижуулах сургалтыг Сүхбаатар суманд зохион байгуулж, 34 сургуулийн 20, 42 цэцэрлэгийн 38 эмч мэргэжилтнүүд хамрагдлаа.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

"Хүүхэд хамгаалын тухай", "Хүүхдийн эрхийн тухай", "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулиудыг сурталчлан таниулах сургалтыг сумдын Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулж, хүүхэд хамгаалал, хамтарсан багаар ажиллах арга зүй, кейс үйлчилгээ үзүүлэх чадварыг олголоо. Хүүхэд харах үйлчилгээг эрхэлж байгаа 9 төвийн 37 иргэнд "Хүүхэд харах үйлчилгээний тухай" хууль, журам, стандарт, хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаарх мэдээ мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх давтан сургалтыг зохион байгуулж "Батламж" гардууллаа.

"Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өвөл, хаврын хурдан морины уралдаан, сунгаа үсэргээнд хүүхдээр морь унуулахгүй байх талаар холбогдох байгууллагуудад зөвлөмж өгч ажиллалаа.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн нийт сумдын нутгаар мал нэмэгдэл тэжээлд орсон Хушаат, Зүүнбүрэн, Ерөө, Цагааннуур, Хүдэр, Жавхлант, Алтанбулаг, Мандал сумдын нутгаар цас ихтэй, цас хатуурснаас малын бэлчээрлэлт саатаж, өвөлжилт хүндэрсэн, цаашид хаваржилт бүхэлдээ хүндрэх төлөвтэй байна. Өвөлжилт хүндэрсэн сумдад Улсын нөөцийн Дархан-Уул аймаг дах салбараас 320 тонн өвсийг үнэ төлбөргүй, 240 тонн тэжээлийг 50 хувиар хямдруулан, малын эм, биобэлдмэлийг олгосоныг аймгийн Засаг даргын А/54 тоот захирамжаар сумдын хуваарийг батлуулан сумдад тараасан. Аймгийн Засаг даргын 02 дугаар сарын А/80 тоот "Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээл борлуулах тухай" захирамжаар аюулгүйн нөөцөөс 114 тн өвс үнэгүйгээр, 45 тн хивэг, 10 тн уурагжуулсан тэжээлийг тараах 17 сумын хуваарийг батлуулан сумдад хүргүүлэхэд бэлэн болгоод байна. Монголын үндэсний радио телевиз, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран "Таван эрдэнэ" нэвтрүүлгийн нэрэмжит шагналд Цагааннуур сумын малчин Ц.Цэрэнчимэд, Сант сумын малчин Б.Цэрэнбат нар "Алтан хурга"-ны эзнээр шалгарсан.

2017 онд нийт 733364 эх мал төллөхөөс 02 дугаар сарын 20-ны байдлаар нийт 6582 мал төллөж үүнээс гүү 20, үхэр 866, хонь 3176, ямаа 6539 төллөөд байна.Төлийн хорогдол 32 үүнээс, тугал 10, хурга 11, ишиг 11 хорогдсон дүн мэдээтэй. Мал төллөлт хараахан жигдэрч эхлээгүй байна.02 дугаар сарын 20-ны байдлаар малын зүй бус хорогдол нийт 3910 үүнээс адуу 76, үхэр 417, хонь 2396, ямаа 1021 үүнээс хээлтэгч 1278, өвчнөөр 1675 бусад нь зүй бусаар хорогдсон мэдээтэй байна.

Сумдын МЭҮН-үүд, ХХААГ-ын дарга нарын 2017 онд байгуулах гурвалсан гэрээнд тусгагдсан халдварт болон паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга

хэмжээнд хамрагдах мал, амьтны хуваарилалтыг захиалгын дагуу эпидемиологийн судалгаанд үндэслэн хийсэн. Мөн Шаамар, Зүүнбүрэн, Сүхбаатар сумдаас ирсэн мал, амьтны халдварт өвчний сэжиг бүхий дуудлага бүрт шуурхай зөвлөгөө, зөвлөмжийг өгч, шуурхай хариу арга хэмжээ авч, Нян судлалын шинжилгээнд Цагааннуур, Зүүнбүрэн сумдаас ирсэн өвчний сэжигтэй үхсэн малаас авсан 17 эмгэгт дээжинд микроскоп, бактериологийн шинжилгээг хийж халдварт өвчний үүсгэгч илрээгүй тул хариуг маягтын дагуу гарган зохих газарт хүргүүлсэн ба өсгөвөр, эмгэгт дээжийн үлдэгдэлд устгал ариутгал хийсэн.

Хүнсний зах, худалдааны төвүүдэд орон нутгаас бэлтгэн нийлүүлэгдэж буй 6731 кг үхрийн махны 53 дээж, 2208 кг хонины махны 96 дээж, 126 кг ямааны махны 6 дээж, 738 кг адууны махны 6 дээж, 100 л сүүний 10 дээж, 60 ширхэг өндөгний 7 дээж, нийт 178 дээжинд МЭАЦ-ийн магадлан шинжилгээ хийж баталгаажуулан тус тус гэрчилгээ олгосон.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 394 дүгээр тогтоолын дагуу сумдаас давхардсан тоогоор 2032 малчны 119488 ширхэг арьс, ширний материалыг хүлээн авч Мал хамгаалах санд хүргүүлсэн.

Хаврын тариалалтын бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд энэ онд тариалах талбай, дутагдаж буй үрийн хэрэгцээ, ургамал хамгааллын бодисын захиалгыг сумдаас авч, газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглагдаж буй техникийн судалгааг гарган Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. Мөн Монгол Улсын Засгийн газраас “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” уриан дор “Мах, сүүний анхдугаар аян”, “Атрын III аян”-ыг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан тус аймагт зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргасан.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:

1.Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалт, дэд бүтцийн талаар:

Онлайн вэб хуудас ашиглан 1:200 000-ны байр зүйн зураг татан авч аймгийн хилийн цэсээр зургийн боловсруулалт хийж олон нийтэд зураг зүйн мэдээллээр үйлчлэх боломжийг бүрдүүлсэн.

Аймгийн хэмжээнд газар тариалангийн бүс нутаг тогтоохтой холбоотой Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.-т заасан хязгаарлалтын бүсийг зураг дээр буулгаж солбицол, газрын нэр, талбайн хэмжээ зэргийг сум тус бүрээр тогтоосон нь 132 нэгж талбарын 717015 га талбай Сэлэнгэ аймгийн газар тариалангийн бүс нутагт хамаарч байна. “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”-ын төсөлтэй танилцаж нийт 5 чиглэлээр санал боловсруулж Барилга хот байгуулалтын яаманд албан тоотоор хүргүүлсэн.

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 32 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж баталгаажуулсан.

Автотээврийн үндэсний төвийн баталсан календарчилсан төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2017 оны 01-р сарын 03-ны өдрийн А/02 тоот захирамжийн дагуу Сүхбаатар суманд суурин тоног төхөөрөмжөөр техникийн хяналтын үзлэгийг явууллаа. Техникийн хяналтын үзлэгт төлөвлөгөөний дагуу 190 тээврийн хэрэгсэл хамрагдахаас суудлын автомашин – 181, ачааны автомашин – 34, автобус 4, тусгай 2, механизм 3, чиргүүл 3, мотоцикл 3 хамрагдаж нийт 230 тээврийн хэрэгсэл хамруулсан нь төлөвлөсөн хэмжээнээс 121-иар давуулан биелүүлсэн байна.

Нийтийн зорчигч тээвэр, ачаа, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслүүд нь тээвэрлэлт гүйцэтгэх тутамдаа автотээврийн хяналтын товчоонд замын хуудас шалгуулж байгаа эсэхэд хяналт тавьж бүртгэлийн дэвтэр хөтлөн ажилласан болно.

Энэ сард нийт 195 аж ахуйн нэгж, байгууллага иргэдийн тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг өөрсдийн ирүүлсэн хүсэлт, холбогдох материалуудыг үндэслэн бүртгэж хөнгөн шуурхай чирэгдэлгүй үйлчилгээг хүргэж

ажиллаа.195 шилжилт хөдөлгөөн хийгдсэнээс гэрчилгээ нөхөлт 8, гэрчилгээ солилт 188, хөдөлгүүр солилт 0, улсын дугаар солилт 58 бүртгэгдсэн байна.

2.Байгаль орчны талаар:

Сэлэнгэ аймагт 2017 оны 02 дугаар сарын 15, 18-ны өдрүүдэд бүх сумдын нутгаар, 19, 20-ны өдрүүдэд зарим сумдын нутгаар 0,0-2,0 мм цас орсон. Ихэнх хугацаанд салхи баруун хойноос болон баруунаас 4-9 м/сек хурдтай. Нийт сумдын нутгаар цасанбүрхүүлтэй, Ерөө, Цагааннуур, Зүүнбүрэн, Хушаат, Түшиг, Хүдэр сум, Бугант тосгоны нутгаар цасны зузаан 22-38 см, цасны нягт 0,18-0,28г/см³, бусад сумдын нутгаар цасны зузаан 10-24 см, цасны нягт 0,17- 0.22 г/см³ байна. Хушаат, Зүүнбүрэн, Ерөө, Цагааннуур, Хүдэр, Жавхлант, Алтанбулаг, Мандал сумдын нутгаар цас ихтэй байгаа тул хунгар газартаа 35-52 см, цасны нягт 0,18-0,34 г/см³, баруун болон хойд, зүүн хэсгээр 21-38см, нутгийн өмнө хэсгээр 31-40 см зузаан цастай байна. Ихэнх сумдын нутгаар 28-33 градус, өдөртөө 14-19 градус хүйтэн, хугацааны сүүлээр дулаарч шөнөдөө 20-22 градус, өдөртөө 9-14 градус хүйтэн байсан.

2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар голуудын мөсний зузаан Сэлэнгэ-Зүүнбүрэн 91см, Сэлэнгэ-Сүхбаатар 69 см, Орхон-Сүхбаатар 88 см, Орхон-Орхон 111 см, Ерөө-Ерөө 81 см, Хараа-Баруунхараа 100 см, Зэлтэр-Зэлтэр 69 см, Хүдэр-Хүдэр 56 см, Ерөө-Дулаанхан 72 см байна. Сэлэнгэ мөрөн Сүхбаатар, Зүүнбүрэн сумуудаар мөсний зузаан олон жилийн дунджаас 5-7 см-ээр бага, Орхон гол Сүхбаатар сумаар олон жилийн дунджаас 7 см-ээр бага бол Орхон сум орчмоор олон жилийн дунджаас 19 см-ээр давсан зузаантай байна. Ерөө гол олон жилийн дундаас 27-36 см-ээр бага, Хараа гол Баянгол сум орчмоор мөсний зузаан олон жилийн дунджаас 31 см-ээр их бөгөөд ёроолдоо хүртэл хөлдсөн, Зэлтэр голын мөсний зузаан олон жилийн дунджаас 20 см-ээр зузаан хөлдсөн, Хүдэр голын мөсний зузаан олон жилийн дунджаас 23 см-ээр бага байна. Сэлэнгэ-Сүхбаатар мөсөн бүрхүүл харзтай бусад голууд битүү мөсөн бүрхүүлтэй байна.

Сүхбаатар суманд агаарын бохирдол, гадаргын усны гидрохимийн шинжилгээ, цацрагийн түвшин нь стандарт хэмжээнээс хэтрээгүй байна. Агаар дахь түгээмэл бохирдуулагч хий болох азотын давхар ислийн дундаж агууламж 0.024 мг/м³, хамгийн их агууламж 0,045 мг/м³, хүхэрлэг хийн дундаж агууламж 0,007 мг/м³, хамгийн их агууламж 0,016 мг/м³ байв.

Мандал сумын ашиглалтын бүсийн ойн санд ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэсэн ажлын тайланг хүлээн авч, Хараа бүсийн сум дундын ойн ангид хүлээлгэж өгч, Хүдэр, Ерөө, Мандал, Баруунбүрэн, Цагааннуур зэрэг сумдын сум дундын Ойн ангийн дарга, инженер ажилтнуудад сургалт зохион байгуулж 10 гаруй инженер техникийн ажилтнууд хамрагдсан.

Долоо.Сум орон нутгийн талаар:

Алтанбулаг сум

Сар шинийн баярт зориулсан “Амар мэндийн аялгуу” тоглолт, сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд “Тэр бөхийн нэр хэн бэ” арга хэмжээг амжилттай зохион байгуулж, ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардуулсан.

Энэ сарын 7, 8, 9-ний өдрүүдэд сумын 1, 2, 3 дугаар багийн иргэдийн Нийтийн Хурал хуралдаж багийн Засаг дарга нараа сонгосон.

Монгол Улсын шадар сайд, Улсын онцгой комиссоос олгосон 20 тн өвс, 10 тн хивгийг 141 өрхөд олгож, “Алтан тариа” ХХК-тай гэрээ байгуулан 15 тн хивэгийг үйлдвэрийн үнээр эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр зээлээр олгосон. Мөн тусламжаар ирсэн ариун цэврийн ком, хөнжил гудам, хүнсний ком, гал тогооны комыг сумын онцгой комиссоор хэлэлцэн 200-аас доош толгой малтай малчин өрхийн жирэмсэн болон хөхүүл ээж, өрх толгойлсон гэр бүлүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг үндэслэн олгож, сумын удирдлагууд, багийн эмч нар малчдаар ажилласан.

Бэлчир бүсийн цэцэрлэгүүдийн дунд уламжлал болон зохиогддог спортын арга хэмжээ тус сумын “Дамбо” цэцэрлэгт болж спортын 3 төрлийн тэмцээнийг 7 цэцэрлэгийн дунд явуулсан. Мөн Монгол зан заншлаараа бахархах, суралцах, ирээдүй хойч үедээ өвлүүлэх зорилгоор эцэг эх, хүүхдүүдийн дунд “Би Монгол хүн” өдөрлөг, нийт ангиудын дунд алаг мэлхий өрж сурах арга хэмжээг зохион байгуулсан.

Сумын эрүүл мэндийн төвөөс “Архидан согтуурахтай тэмцэх”, “Малчдын эрүүл мэндийн дэмжье” сарын аяныг явуулж, албан байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд 4 төрлийн 230 ширхэг гарын авлага тарааж, явуулын ЭХО шинжилгээ, зүрхний цахилгаан бичлэг хийж эрүүл мэндийн тусламжийг үзүүлсэн.

Баянгол сум:

Сар шинийн баярыг тохиолдуулан жил бүр уламжлал болсон ахмад буурлууддаа хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж, 104 аж ахуйн нэгж 411 ахмад настанд хүндэтгэл үзүүлснээс гадна сар шинийн баярыг тохиолдуулан сумын 75-аас дээш настай 74, Засаг даргын Тамгын газраас тэтгэвэрт гарсан 14 ахмад настныг хүлээн авч Засаг даргын хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулсан.

ХҮИ- жарны “Муу нүүр” хэмээх гал бичин жилийн сумын хөдөлмөрийн аваргуудыг тодруулж, бүрэн дунд сургуулийн багш А.Тунгаа, Гал түймэр унтраах 40-р ангийн гал сөнөөгч Р.Ганболд, Эрүүл мэндийн төвийн лаборант Х.Даваадулам, Хараа багийн иргэн Ц.Ганболд, Гонир багийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгч А.Жаргал, Хараа багийн малчин Я.Баатарсүрэн, Баян багийн малчин Г.Даваасүрэн, Гонир багийн малчин Д.Батсүх, бүрэн дунд сургуулийн сурагч Ц.Нарангарав нар шалгарч сумын Засаг даргын өргөмжлөл, аваргын энгэрийн тэмдэг, үнэ бүхий зүйлээр шагнагдсан. Мөн сумын алдарт уяачаар Хараа багийн иргэн А.Батболд, Баян багийн иргэн Г.Ганхөлөг, Н.Эрдэнэбат Гонир багийн иргэн нар шагнагдлаа.

Сумын “Мөсний баяр” арга хэмжээг 2-р сарын 25-нд зохион байгуулж, мөсний шагай, Үндэсний дээлтэй шилдэг хос, Шилдэг отог, Олс таталтын тэмцээнийг явуулсан.

Аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулагдсан аймгийн аварга шалгаруулах U-15 тэмцээнд УТБДС-ийн Э.Энхбаяр дасгалжуулагчтай баг тамирчид амжилттай оролцож Т.Тэмүүжин ахлагчтай эрэгтэй баг тамирчид хүрэл медаль, Б.Анударь ахлагчтай эмэгтэй баг тамирчид хүрэл медаль, 2-р сарын 5-нд Мандал сумын Хэрх тосгонд болсон Хараа бүсийн 6-8-р ангиудын дундах тойргийн сургуулиудын аварга шалгаруулах Гар бөмбөгийн тэмцээнд Д.Эрдэнэбаатар багштай 76 ангийн эмэгтэй баг тамирчид амжилттай оролцож мөнгөн медаль хүртлээ.

Ардын авьяастан З.Алтанхуягийн “Ажнай хүлгийн аялгуу дуутай нутаг мину”, МУСТА В.Баттулгын “Эр хүн гэдэг эмзэгхэн ч юм уу даа” уран бүтээлийн тайлан тоглолтыг тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 250 гаруй хүн үзэж сонирхсон.

Сумын эрүүл мэндийн төв тайлант хугацаанд амбулаториор нийт 401 иргэнийг үзлэгт хамруулан, дээд шатлалын эмнэлэгт 23 иргэнийг онош тодруулахаар илгээн, хүлээн авах хэсгээр 324 иргэнд өдрийн эмчилгээг эмчийн заалтаар хийж үйлчилсэн. Түргэн тусламжийн нийт 126 дуудлага хүлээн авснаас хөдөө багт 31 дуудлаганд явж үйлчилсэн.

Эх хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээл хөтөлбөрийн хүрээнд 0-5 насны 186 хүүхдийг жинлэн, товлолын дагуух дархлаажуулалтанд 100 хувь хамруулж, жирэмсний хяналтанд 46 эх байна.

Тайлант сард шинэ төрсөн 12, шинээр гэр бүл болсон 3, эцэг тогтоолтын бүртгэл 2, овог нэрээ өөрчлүүлсэн 1, нас барсан 1, иргэний үнэмлэх олголт шинээр 10, дахин 5, сунгалт 26, шилжин ирсэн 23, шилжин явсан 30, иргэний шинэчилсэн бүртгэлд 16 нас хүрсэн 12, иргэний үнэмлэхээ сунгуулах 17 иргэнийг тус тус бүртгэсэн байна.

Сумын хэмжээнд 2016-2017 оны өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд улсын Онцгой комиссын бүрэлдэхүүний хамт 2-р сарын 20-ны өдөр тус суманд ажиллаж Улсын өвс тэжээлийн аюулгүйн нөөцөөс 40 тн өвс, 30 тн хивэг олгосныг 816 малчин, мал бүхий иргэдэд тараан өгсөн.

2017 оны 02 сарын 22-ны байдлаар үнээ 464, эм хонь 191, эм ямаа 79 нийт 734 толгой мал төллөж, том малын хорогдол 163 гараад байна.

Зүүнбүрэн сум:

Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж 79 төрийн албан хаагчдыг хамруулан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, болон Засаг даргаас 2017 онд баримталж ажиллах бодлого чиглэлээ тодорхойлон, сумын Засаг дарга Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвийн дарга, Соёл мэдээллийн төвийн эрхлэгч нартай 2017 оны үр дүнгийн гэрээгээ байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүй, Захиргааны ерөнхий хуулийн талаар сургалт явуулж, удирдах албан тушаалтнуудад 5, төрийн албан хаагчдад хандсан 4 заалт бүхий УРИАЛГА гарган хэрэгжүүлж байна.

Иргэний гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шинэ төрсөн 5, эцэг тогтоолт 1, овог нэр өөрчлөлт 1, нас баралт 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 8, иргэний үнэмлэх олголтын 16, шилжин ирсэн 15 нийт 64 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, цахим иргэний үнэмлэх шинээр авах 5, сунгалт хийлгэх 3, хаяж үрэгдүүлсэн 2 иргэнийг дахин үнэмлэхжүүлэх боломжоор ханган ажиллалаа.

Сар шинийн баярыг тохиолдуулан сумын “Сайн малчин”-аар Д.Болдхүү, сумын “Алдарт уяач”-аар М.Харцага, Д.Ганзориг, оны “Шилдэг уяач”-аар Д.Болдхүү, оны “Шилдэг унаач хүүхэд”-ээр Н.Нандинцэцэг нар шалгарсан. Мөн “Цагаан сар 2017” үзэсгэлэн худалдааг 2017 оны 02 дугаар сарын 13-нд зохион байгуулж давхардсан тоогоор 30 иргэн 325 кг ааруул, 50 кг шар тос, 96 кг цагаан тос, 160 л сүү, 115 л шимийн архи, 60 кг жимс жимсгэнэ, 90 шил алаг салат, 160 өргөст хэмх, 20 шил улаан манжин, 10 кг луувангийн салат, 30кг кимчи, 50 кг өөхөн тос гэсэн бүтээгдэхүүнээр оролцож 4457,0 мянган төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Орон нутгийн “Сэлэнгийн мэдээ” сониноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Оны 9-н алдартан шалгаруулах арга хэмжээнд Ч.Бадрал, Бүжинхэн хүүхэд харах үйлчилгээний төв оролцон Бүжинхэн хүүхэд харах үйлчилгээний төв оны 9 алдартны нэгээр шалгарлаа.

Сар шинийн баярыг тохиолдуулан ардын язгуур урлаг, үндэсний соёлоо сурталчлан сумын ардын авьяастнуудыг оролцуулан “Сар шинийн эгшиглэн” концертыг зохион байгууллаа.

Сумын эрүүл мэндийн төв амбулатороор 328 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 192, урьдчилан сэргийлэх үзлэгээр 53, диспансерийн хяналтаар 45, гэрийн идэвхтэй эргэлтээр 23, дуудлагаар 14 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүллээ.

2016 онд ноос тушаасан 99 малчин өрхийн урамшууллын материалыг хянан шалгаж дээд шатны байгууллагад хүргүүлж, иргэдийн түлшний модны хэрэглээг хангах зорилгоор 52 иргэнд 208 м3 мод бэлтгэх зөвшөөрөл олголоо.

2016 оны улаанбуудайн нөөцөлсөн үр, 2017 онд тариалах талбайн хэмжээ, 2017 оны ургамал хамгааллын бодис бордооны захиалгыг иргэн, аж ахуйн нэгж бүрээр гаргаж холбогдох дээд газарт хүргүүлж ажиллаа. Төмс, хүнсний ногоо эрхлэгч 30 иргэнийг цахим санд бүртгэж коджууллаа.

Жавхлант сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаан 02 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж сум хөгжүүлэх сангийн чиглэл, зээлийн хүүг шинэчлэн батлах тухай, сум хөгжүүлэх сангаас зээл олгох, төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай, сумын 2017 оны төсвийн тодотгол хийх тухай, сумын ИТХ-ын 2017 оны ажлын төлөвлөгөө батлах, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай, улаан загалмайн салбар зөвлөлийг шинэчлэн батлах тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Монгол Улсын Засгийн газраас олгосон 40 тн өвс буцалтгүй тусламжаар, 20 тн хивэг хөнгөлөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулж, МУЗН-ээс 39 өрхөд хэрэглээний багц буцалтгүй тусламжаар олголоо.

Сумын Засаг даргын захирамжаар 195 ахмад настныг суманд үйл ажиллагаа явуулж буй 41 аж ахуйн нэгж байгууллагад хуваарилан сар шинийн хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, 70-аас дээш насны 43 ахмад настанд сумын Засаг даргын, 85—аас дээш насны 3 ахмад настанд аймгийн Засаг даргын бэлгийг гардуулж, хүндэтгэл үзүүллээ.

Аймгийн ИТХ-ын ажлын албаас НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Их хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран зохион байгуулсан “Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхижуулах сургалтанд нийт 16 төлөөлөгч хамтаргадаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн.

Орхонтуул сум:

Тайлант сард сумын “Малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, мал аж ахуйн салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар малчидтайгаа хамтран ажиллах талаар санал бодлоо солилцсоноос гадна аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, сум дундын Прокурорын газар, сум дундын Цагдаагийн тасгийн холбогдох албан тушаалтнууд оролцож малчид мэдээлэл зөвлөгөө өглөө. Малчдын зөвлөгөөнд 250 гаруй малчид оролцож сумын Малчдын зөвлөл”-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд малчдын үүрэг оролцоог хангах, малчдыг малаа байнгын хариулагатай байлгах талаар зохион байгуулалтын ажлуудыг хийхээр Малчдын зөвлөлийн ажиллах журмн төслийг боловсруулан зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн батлууллаа.

Мөн сумын Засаг даргын Тамгын газраас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний нэр төрөл, бүрдүүлэх материал бүхий мэдээлэл агуулсан 2017 оны Цаг тооны бичиг болон малчдад чухал шаардлагатай утасны жагсаалт бүхий ном гарган тарааж, Орхонтуулын мэдээ сонины 2017 оны 01 тоот дугаарыг гарган 500 хувь хэвлүүлэн иргэдэд хүргэлээ.

Сар шинийн баярыг тохиолдуулан Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдтэй хамтран 320 ахмадад гарын бэлэг өгч хүндэтгэл үзүүлж, Монгол Улсын Ерөнхий сайдын болон аймгийн Засаг даргын гарын бэлгийг ахмадуудын гэрт нь хүргэж өгч гардууллаа. Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах хурдан шуурхай байдлыг хангах, иргэдийн цаг хугацааг хэмнэх зорилгоор оны эхнээс “Хөтөч жижүүр”-ийн ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн дагуу багийн Иргэдийн Нийтийн Хурлууд болж иргэдээс олонхийн санал авсан багийн Засаг дарга нарыг батламжилан томилж Үр дүнгийн гэрээ байгуулан заавар зөвлөмж өгч ажиллалаа.

2016 онд сумын мал аж ахуйн үйлдвэрлэл хэвийн жигд хангагдан явж мал сүрэг 15,6%-иар өсч, нийт сүргийн дотор үхэр, хонины эзлэх хувь 61,2% болж, тэмээ-410, адуу-13726 толгой, үхэр-19557, хонь-106511, ямаа-75856 толгой нийт 216060 толгой мал тоологдож өнгөрсөн оныхоос тэмээ-113,8%, адуу-113,6%, үхэр 113,3%, хонь-116,8%, ямаа 115,2%-иар өсч оны эхний төллөх 84967 хээлтэгчийн 81762 хээлтэгч төллөж гарсан төлийн 99,6% бойжиж 100 эхээс ботго 74, Унага 78 тугал 81, хурга 97, ишиг 97 бойжуулсан байна.

Он гарсаар сумын хэмжээнд 883 мал зүй бусаар хорогдсоноос адуу 64, Үхэр 90, хонь 400, ямаа 329, үүний 5,7% өвчнөөр, 6,2% нь чононд идүүлсэн ба нийт хорогдсон малын 88 %-нь өвчний бус шалтгаанаар хорогдсон байна.

2017 онд төллөх 96290 толгой хээлтэгчийн 8354 төллөж гарсан төлийн 99,1% бойжиж, одоогийн байдлаар 71 төл хорогдоод байна.

Цас зудны хамгийн их хүндэрч байгаа газар Хоньч, Бяцхан ус, Хөхий, Өвөр булаг Өлзий нуга, Цацат, Хонгор-Овоо зэрэг газруудад өвөлжиж байгаа айл өрх нилээд хүнд нөхцөлтэй байна. Дээрх газруудад нийт 124 малчин өрх өвөлжиж байгаа. Мөн сумын төвийн айл өрхүүдийн мал ядарч сульдах, хээл хаях байдал гарч байна.

Хушаат сум:

Сумын 30 жилийн ойг тохиолдуулан “Талын нар” телевизийн ярилцлага нэвтрүүлгийг бэлтгэн явуулж, 1987 онд сум байгуулагдахад ажиллаж байсан 120 гаруй ажиллагсад оролцон 25 иргэн дурсамж ярилцлага өгсөн.

“Хушаатад үйлдвэрлэв” сар шинийн үзэсгэлэн худалдааг 2 дахь жилдээ зохион байгуулж 10 гаруй үйлдвэрлэгч оролцон 1.0 сая гаруй төгрөгийн борлуулалт хийгдлээ.

Сумын “Цасны баяр-2017” арга хэмжээг зохион байгуулж сумын Соёлын төв, ХААН банк, Төрийн банкны хамт олон тэргүүлээ.

Тайлант сард үрчлэлт 1, овог нэр өөрчлөлт 1, шилжин явсаны 5, шилжин ирсэний 6, гэрлэлт цуцлалтын 1, цахим үнэмлэх дахин авах 2, биеийн давхцахгүй өгөгдлийн 7, үл хөдлөх хөрөнгийн эрхийн 3, газар өмчлөх эрхийн 4, иргэний үнэмлэх олголтын 6 нийт 36 бүртгэл хийгдлээ.

Улсын онцгой байдлаас зудтай сумдад өгсөн тусламжийн 500 боодол өвс, хямдралтай үнээр олгосон 400 шуудай хэвэгийг багийнхаа малчин болон мал бүхий 140 иргэдэд хувиарлаж олгосон ба сумын фондод 1300 боодол өвс хямд үнээр авч малчдад тараах ажлыг зохион байгуулж, өнөөдрийн байдлаар 300 боодол өвсийг мөн малчин болон мал бүхий өрхөд хувиарлан 50 өрхөд олгосон. Мөн Монголын улаан загалмайн нийгэмлэгээс цас зудтай хүндрэлтэй үед цөөн малтай, олон ам бүлтэй хөгжлийн бэршээлтэй, 0-5 насны хүүхэдтэй малчин өрхөд ирүүлсэн тусламжийг цөөн малтай өрхүүдэд судалгааг үндэслэн 23 өрхийг сонгон олгож, бэлэн мөнгөний тусламж хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон, 16-аас дээш насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй 19 өрхийг хамруулан 4644.0 мянган төгрөгийг бэлнээр олгууллаа.

Сумын хэмжээнд 927 том мал зүй бусаар хорогдсон ба үүнээс үхэр 170, хонь 325, ямаа 432, толгой мал хорогдсон байна. Мал төллөлтийн мэдээгээр тугал 82, хурга 37, ишиг 36 толгойгоор нэмэгдэн эсэн мэнд бойжиж байна.

Хүдэр сум:

Тайлант сард сумын Засаг даргын зөвлөл 2 удаа хуралдаж, өнгөрсөн оны ажлын явц, цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон цаг үеийн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Мөн Сумын Онцгой комисс 2017 оны 01-р сарын 31-ний өдөр хуралдаж Аймгийн МХГ-ын мал эмнэлэгийн хяналтын улсын байцаагчийн 2017 оны 1-р сарын 31-ны өдрийн 18-02-010/16 тоот хорио цээрийн дэглэм бууруулах тухай дүгнэлтийг хүлээн авч холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан. Хязгаарлалтын дэглэмийн үед ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг гаргаж, голомтын 9 өрх болон малчин 90 өрхөд байнгын заавар, зөвлөгөө өгч өдөр тутам малдаа үзлэг тандалтыг хийхийг зөвлөж ажилласан. Мөн ариутгал халдваргүйжилт хийх талаар заавар өгч нийт 30 малчин өрхөд малитон ариутгалын цацлагыг өгч, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн.

Сумын иргэдийн Төлөөлөгчдын Хурлаас уриалга гаргаж Малын гоц халдварт хонины цээцг өвчнөөр хонио алдсан малчдад туслах сайн үйлсийн аяныг 14 хоногийн хугацаанд зохион явуулсан. Тус аянд "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХКомпани нэгдэж 500 боодол өвс, Зэрлэгийн шугуй ХХК -100,000 төгрөг, Худалдааны төвийн хамт олон-165500 төгрөгний хүнсний бүтээгдэхүүн, 3.Эрдэнэцогт захиралтай "Хүдэр од трейд" ХХКомпани - 10 шуудай хивэг, С.Отгонцэцэг захиралтай "Хүдэр дэлгэрэх" ХХКомпани -260,0 мянган төгрөгний хүнсний бүтээгдэхүүн болон 260,0000 мянган төгрөг, сумын ИТХ-с 150,000 мянган төгрөг, ЕБС-ын хамт олноос 1 сая төгрөгний эд материал, ЭМТ-ийн хамт олноос 86000 төгрөг хандивлаж, сумын 6 малчин өрхөд хүлээлгэн өгсөн.

Сумын ГХУС “Хүчирхийлэл хүүхэд бидний ирээдүй биш” дэвжээ тэмцээн, бага ангийн сурагчдын дунд “АХА” тэмцээнийг тус тус зохион байгуулснаас гадна аймгийн төвд зохиогдсон “Формула L2” аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Цагааннуур суманд зохиогдсон гар бөмбөгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд сурагчдын амжилттай оролцуулсан.

Аймгийн Боловсрол соёл урлагийн газраас зохион байгуулсан бүсийн багш нарын зөвлөн туслах ажлын хэсэг 2017.02.03-ны өдөр сумын цэцэрлэг дээр ажиллаж сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилт, сургалтын орчин бүрдүүлэлт, хүүхдийн

үнэлгээ, 3 багшийн хөгжүүлэх үйл ажилагаатай танилцаж, багш нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай хүүхэд бүрт хүргэх суурь зарчмыг хэрэгжүүлж багш нарын мэргэжлийн чадавхийг дээшлүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан. Энэ үеэр Ерөө бүсийн цэцэрлэгүүдийн багш нарын болон Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэг дээр зохион байгуулагдсан сургалтанд “Жимсхэн” цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш нарын хамруулсан.

Аймгийн стандартчилал хэмжил зүйн хэлтсээс сумын төвд үйл ажиллагаа явуулдаг 3 зоогийн газар, 26 дэлгүүрт ашиглагдаж буй хэмжих хэрэгслүүдэд шалгалт, баталгаажуулалт хийж, 16 худалдаа үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгохоос 9 газар баталгаажуулалтанд тэнцсэн байна. Ерөө суманд болсон худалдаа үйлчилгээний ажилтны бүсийн зөвлөлгөөнд сумын худалдаа үйлчилгээний ажилтнууд оролцсон. "Хүдэр цагаан сар-2017" үзэсгэлэн худалдаанд нийт 10 иргэн оролцож сүү цагаан идээ даршилсан бүтээгдэхүүн, ноос ноолууран хувцас, мах махан бүтээгдэхүүнийг борлуулж, нийт 2,7 сая төгрөгийн борлуулалт хийгдлээ.

Түшиг сум

Сумын ИТХ-ын 5 дугаар хуралдаанаар сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэж, “Иргэн нь ажилтай, өрх нь орлоготой, хөгжлийн төлөө хамтдаа” зорилгыг дэвшүүлж, нийт 66 бодлогын зорилтыг хэрэгжүүлэхээр батлуулсан. Төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэх, иргэдийн санал хүсэлтийг сонсох зорилгоор энэ сарын 07-08-ны өдрүүдэд ажлын хэсэг ажиллаж, 249 өрхөд мэдээлэл хийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн.

Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн сумдад олгосон 20 тн өвс, 20 тн хивэгийг малчин болон мал бүхий 160 гаруй өрхөд хуваарилан олгож, олон улсын болон дотоодын байгууллагуудын хүмүүнлэгийн тусламжийн бараа материалыг 40 өрхөд, ариун цэврийн багцыг 16 өрхөд, гал тогооны багцыг 8 өрхөд тус тус олгосон.

“Цагаан сар” нэгдсэн арга хэмжээний хүрээнд сумын 144 ахмад настанд аж ахуйн нэгж байгууллагууд хуваарилан авч гарын бэлэг тараан хүндэтгэл үзүүлсэн ба байгууллага, аж ахуйн нэгжид ахуйн гал түймэр болон гарч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж өгссөн.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР